



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 12

Өмнөдэлгэр сум

Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр
хэрэгжүүлэх зээлийн ашиглалт,
эргэн төлөлтөд хяналт тавих
хороо байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 2 дугаар Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1.Өмнөдэлгэр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хяналтын хорооны дарга:	В.Лутбэх	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч
Нарийн бичгийн дарга:	Т.Одончимэг	Сумын хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Ж.Ганчимэг	Хүнс хөдөө аж ахуйн газрын хоршоо, жижиг дунд, ахуй үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн
	Б.Сэр-Од	Санхүү, төрийн сангийн мэргэжилтэн
	М.Мөнхтөр	Төрийн бус байгууллагын төлөөлөл

2.Журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн А/18 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3.Хяналтын хороо нь журмын дагуу хяналт тавин, тайланг бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг Хяналтын хорооны дарга (В.Лутбэх)-д даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хороодын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ